19.

НЗД-ын 1993 оны А282-р захирамжаар хүчингүй.

**БНМАУ-ын ХУДАЛДАА, БЭЛТГЭЛИЙН ЯАМ**
**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО,**
**УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ**
**ЗАХИРГААНЫ ТОГТООЛ**

1988 оны I дүгээр сарын 7-ны өдөр — Дугаар 16/03/06 — Улаанбаатар хот

"Тамирчин" гуанз ажиллуулах тухай

"Тамирчдын бэлтгэлийг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1982 оны 13 дугаар тогтоолыг хэрэгжүүлж, тамирчдыг байнга амт чанар сайтай хоолоор үйлчлэх зорилгоор ТОГТООХ нь:

1. Сүхбаатарын районы Нийтийн хоолны трестийн харьяа 48 дугаар гуанзыг 1988 оны I дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн улсын шигшээ багийн тамирчдын бэлтгэл, цугларалт, олон улсын болон улсын аварга шалгаруулах тэмцээний баг тамирчдад үйлчилдэг зориулалтын "Тамирчин" гуанз болгон 2 ээлжээр ажиллуулахыг Улаанбаатар хотын Нийтийн хоолны удирдах газар /н.Урианхай/-т даалгасугай.

2. Биеийн тамир, спортын улсын хорооны санхүү төлөвлөгөөний хэлтэс /н.Аюурзана/, Худалдаа бэлтгэлийн яамны худалдааны хэлтэс /н.Банзрагч/, Хотын төлөвлөгөөний комисс /н.Дугаржав/, худалдааны хэлтэс /н.Сүхээ/, Нийтийн хоолны удирдах газар /н.Урианхай/-т ДААЛГАХ нь:

а/ "Тамирчин" гуанзны хэрэгцээт мах, сүү, сүүн бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо зэрэг гол нэр төрлийн бүтээгдэхүүнийг Улсын төлөвлөгөөний комиссын 1969 оны 154 дүгээр тогтоолоор "Спортын шаардагдах хоолны илчлэгийг 6000-8000 их калор байхаар" тогтоосон заалтыг хангаж чадах хэмжээгээр тус гуанзны хэрэгцээнд жил, улирлын хуваарьтайгаар баталж, бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас шууд хангуулж байсугай;

б/ "Тамирчин" гуанзны зарим тоног, төхөөрөмжийг шинэчлэн тохижуулах, үйлчилгээг сайжруулах арга хэмжээг 1988 оны I дүгээр сард багтаан авах;

в/ "Тамирчин" гуанзны үйлчилгээний ажлын тайланг хагас, бүтэн жилээр үйлчлүүлэгчдэд тавьж хэлэлцүүлж байх.

3. Биеийн тамир, спортын улсын хорооны санхүү төлөвлөгөөний хэлтэс /н.Аюурзана/-т ДААЛГАХ нь:

а/ Үйлчлүүлэх баг тамирчдын тоог оны эхнээс улирлын хуваарьтай тооцож, хангамжийг холбогдох газруудтай хамтран боловсруулан хэрэгжүүлсүгэй;

б/ "Тамирчин" гуанзаар үйлчлүүлэх тамирчдын хоолны үнийн 70-аас доошгүй хувийг урьдчилан шилжүүлэн дараа сарын 5-ны дотор харилцан тооцож байсугай;

в/"Тамирчин" гуанзны жилийн хэрэгцээт мах, сүү, цагаан идээний 15 хувийг 1988 оноос, 1990 оноос махны 30, сүү, цагаан идээний 50-иас доошгүй хувийг байгууллагынхаа туслах аж ахуйгаас хангах арга хэмжээ авч ажилласугай;

г/"Тамирчин" гуанзны хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүнийг бэлтгэн нийлүүлэгч байгууллагаас татан авахад гуанзны захиалгаар тухай бүр унаагаар үйлчилж гуанзны хоollох заалны талбай, суудлын тоог нэмэгдүүлж, тохижилт соёлжилтыг сайжруулах арга хэмжээ авч ажилласугай.

4.Тогтоолын биелэлтэнд байнгын хяналт тавьж, биелэлтийг хагас бүтэн жилээр 3 байгууллагын удирдлагуудад танилцуулж байхыг улсын худалдааны байцаан шалгах газар /н.Лхам/, Худалдааны хэлтэс /н.Сүхээ/, хариуцлагатай нарийн бичгийн дарга н.Жамбалсанжидад үүрэг болгосугай.

| | | |
|---|---|---|
| ХУДАЛДАА,БЭЛТГЭЛИЙН ЯАМНЫ САЙД | БИЕИЙН ТАМИР,СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ ДАРГА | УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА |
| Б.ШАРАВСАМБУУ | Д.ДАШДОВДОН | С.МӨНХЖАРГАЛ |